



**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2026 оны 06 сарын 29 өдөр

Дугаар А/55

Баян-Өндөр сум

Сургалт зохион байгуулж, хөрөнгө
гаргах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16.5.5 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Хүүхдийн нүдний эмгэгийн эрт илрүүлэг үзлэг, нүдний улаан рефлекс, хүүхдийн хараа шалгах аргачлал” сэдэвт сургалтын удирдамжийг нэгдүгээр, шаардагдах төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Үйл ажиллагааг зохион байгуулахад шаардагдах 7,187,500 (долоон сая нэг зуун наян долоон мянга таван зуун) төгрөгийг нэмэлт санхүүжилтийн данснаас гаргахыг Салбарын санхүү бүртгэл, мэдээлэл, нягтлан бодохын ажилтан (Г.Отгонцэцэг)-т зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний бодлого төлөвлөлт хариуцсан ахлах мэргэжилтэн (Н.Мөнгөнцацралт)-д даалгасугай.

ДАРГА



Ц.МӨНХЦЭЦЭГ

Эрүүл мэндийн газрын даргын 2026 оны
06 дугаар сарын 29-ны өдрийн
1/53 дугаар тушаал I хавсралт



“ХҮҮХДИЙН НҮДНИЙ ЭМГЭГИЙН ЭРТ ИЛРҮҮЛЭГ ҮЗЛЭГ, НҮДНИЙ УЛААН РЕФЛЕКС, ХҮҮХДИЙН ХАРАА ШАЛГАХ АРГАЧЛАЛ” СЭДЭВТ СУРГАЛТЫН УДИРДАМЖ

Үндэслэл:

"ОРБИС Интернэшнл" олон улсын төрийн бус байгууллагын Монгол дахь салбараас хэрэгжүүлж буй "Алслагдмал бүс нутагт нүдний тусламж үйлчилгээг чанартай хүргэх загвар" төслийн хүрээнд Орхон аймагт нүдний эрүүл мэндийн чиглэлээр цогц арга хэмжээ авч хэрэгжүүлж байна.

Сүүлийн жилүүдэд хүүхдийн харааны өөрчлөлт, хугарлын гажиг, төрөлхийн болон олдмол нүдний эмгэгийн тохиолдол нэмэгдэх хандлагатай байгаа бөгөөд эдгээрийг эрт илрүүлэн шаардлагатай тусламж үйлчилгээнд цаг алдалгүй хамруулах нь чухал ач холбогдолтой байна. Иймд анхан шатны эрүүл мэндийн байгууллагын эмч, эх баригчдын хүүхдийн нүдний эмгэгийг эрт илрүүлэх мэдлэг, ур чадварыг бэхжүүлэх шаардлага тулгарч байна.

Энэхүү сургалтаар оролцогчдыг хүүхдийн нүдний бүтэц, үйл ажиллагаа, түгээмэл тохиолдох эмгэг, харааны өөрчлөлтийг таних, нүдний улаан рефлекс болон хараа шалгах аргачлалыг эзэмшүүлэх, Арклайт багаж ашиглан анхан шатны үзлэг хийх чадварт сургах зорилготой.

Зорилго:

Сум, өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, эх баригч нарт хүүхдийн нүдний эрүүл мэндийн талаарх суурь мэдлэг, хүүхдийн нүдний эмгэгийг эрт илрүүлэх ур чадвар олгож, чанартай тусламж үйлчилгээ үзүүлэх чадавхыг нэмэгдүүлэхэд оршино.

Зохион байгуулагч:

- ОРБИС интернэшнл ОУ-н байгууллага
- Эрүүл мэндийн газар
- Бүсийн оношилгоо эмчилгээний төв

Хамрах хүрээ:

Сум, өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, эх баригч нар

Хугацаа, байршил:

2026 оны 06 сарын 29,30-ны өдөр 09:00 цаг, Эрүүл мэндийн дэмжих төв сургалтын танхим

Сургалтын хөтөлбөр:

Сургалтын сэдэв	Хугацаа /мин/	Хариуцах эзэн
2026.06.29-ны өдөр		

Сургалтад оролцогчдын бүртгэл Цай кофе Сургалтын өмнөх асуумж	09:30-10:00	Эрүүл мэндийн газар ХБӨТСХМэргэжилтэн А.Хонгорзул
Сургалтын нээлт	10:00-10:05	Орхон аймгийн эрүүл мэндийн газрын дарга Ц.Мөнхцэцэг
Хүүхдийн нүдний эмгэгийн эрт илрүүлэг, илгээлт, эрт илрүүлгийн ач холбогдол, Нүдний угийн улаан рефлекс	10:05-10:25	БОЭТ-н амбулоторийн эрхлэгч, нүдний их эмч Г.Эрдэнэтуяа
Арклайт багажийн хэрэглээ	10:25-11:35	
Хүүхдийн хараа шалгах аргачлал	11:35-11:50	
Цайны завсарлага 11:50-12:00 цаг		
Оролцогчдыг 2 групп болгож хувиарлах	12:00-12:05	БОЭТ-н амбулоторийн эрхлэгч, нүдний их эмч Г.Эрдэнэтуяа БОЭТ нүдний эмч Б.Отгонжаргал
Групп тус бүр хариуцсан багштайгаа нүдний угийн улаан рефлекс шалгах, хараа шалгах дадлага	12:05-13:15	ЭХЭМҮТ-ийн НМЗТ-ийн эмч Н.Отгонсүрэн БОЭТ-н амбулоторийн эрхлэгч, нүдний их эмч Г.Эрдэнэтуяа Орхон аймгийн БОЭТ-ийн нүдний эмч Б.Отгонжаргал
Улирал бүр ирүүлэх тоон тайлан	13:15-13:20	Орбис ОУБ Монгол дахь салбарын төслийн зохицуулагч Д.Мандхай Орхон аймгийн ЭМГ-ын Халдварт бус өвчний тандалт сэргийлэлт хариуцсан мэргэжилтэн А.Хонгорзул
Үдийн хоол 13:30-14:00 цаг		
3 баг тус бүр 3 өрх дээр Нүдний угийн улаан рефлекс, хараа шалгах үзлэг зохион байгуулах, Хяналт үнэлгээ зохион байгуулах	14:30-17:00	Зохион байгуулагчид
2026.06.30-ны өдөр		
Бүртгэл	09:30-10:00	Эрүүл мэндийн газар А.Хонгорзул
Хүүхдийн нүдний эмгэгийн эрт илрүүлэг, илгээлт, эрт илрүүлгийн	10:00-10:25	БОЭТ-н нүдний их эмч Б.Отгонжаргал

ач холбогдол, Нүдний угийн улаан рефлекс		
Арклайт багажийн хэрэглээ	10:25-11:35	
Хүүхдийн хараа шалгах аргачлал	11:35-11:50	
<i>Цайны завсарлага 11:50-12:00 цаг</i>		
Оролцогчдыг 2 групп болгож хувиарлах	12:00-12:05	БОЭТ-н амбулоторийн эрхлэгч, нүдний их эмч Г.Эрдэнэтуяа БОЭТ нүдний эмч Б.Отгонжаргал
Групп тус бүр хариуцсан багштайгаа нүдний угийн улаан рефлекс шалгах, хараа шалгах дадлага	12:05-13:15	ЭХЭМҮТ-ийн НМЗТ-ийн эмч Н.Отгонсүрэн БОЭТ-н амбулоторийн эрхлэгч, нүдний их эмч Г.Эрдэнэтуяа Орхон аймгийн БОЭТ-ийн нүдний эмч Б.Отгонжаргал
Улирал бүр ирүүлэх тоон тайлан	13:15-13:20	Орбис ОУБ Монгол дахь салбарын төслийн зохицуулагч Д.Мандхай Орхон аймгийн ЭМГ-ын Халдварт бус өвчний тандалт сэргийлэлт хариуцсан мэргэжилтэн А.Хонгорзул
<i>Үдийн хоол 13:30-14:00 цаг</i>		
3 баг тус бүр 3 өрх дээр Нүдний угийн улаан рефлекс, хараа шалгах үзлэг зохион байгуулах, Хяналт үнэлгээ зохион байгуулах	14:30-17:00	Зохион байгуулагчид

Хяналт, үнэлгээ:

№	Байгууллагын нэр	Хугацаа	Хяналт үнэлгээ, зөвлөн туслах үзлэг зохион байгуулах
1.	Анхны-Оч өрхийн эрүүл мэндийн төв	2026.06.29 14:30-17:00	ЭХЭМҮТ-ийн НМЗТ-ийн эмч Н.Отгонсүрэн
2.	Мөнхсүндрэл өрхийн эрүүл мэндийн төв		БОЭТ-н амбулоторийн эрхлэгч, нүдний их эмч Г.Эрдэнэтуяа
3.	Үйлсбадрах өрхийн эрүүл мэндийн төв		Орхон аймгийн БОЭТ-ийн нүдний эмч Б.Отгонжаргал
4.	Мэндцэцэн өрхийн эрүүл мэндийн төв		ЭХЭМҮТ-ийн НМЗТ-ийн эмч Н.Отгонсүрэн

5.	Мөнхийн гэгээ өрхийн эрүүл мэндийн төв	2026.06.30 14:30- 17:00	БОЭТ-н амбулаторийн эрхлэгч, нүдний их эмч Г.Эрдэнэтуяа
6.	Учралтбаяр өрхийн эрүүл мэндийн төв		Орхон аймгийн БОЭТ-ийн нүдний эмч Б.Отгонжаргал

Жич: Өрхийн эрүүл мэндийн төв бүр 4-6 насны 30-35 хүүхдийг урьдчилан бүртгэн, үзлэгийн хугацаанд хамруулах бэлтгэл, зохион байгуулалтыг хангахад анхаарна уу.

Хүрэх үр дүн:

- Сум, өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, эх баригчид хүүхдийн нүдний бүтэц, үйл ажиллагааны талаар суурь мэдлэгтэй болно.
- Хүүхдийн дунд түгээмэл тохиолддог нүдний эмгэг, харааны өөрчлөлтийг эрт илрүүлэх чадвартай болно.
- Нүдний улаан рефлекс болон хараа шалгах аргачлалыг зөв хэрэгжүүлэх мэдлэг, ур чадвар эзэмшинэ.
- Хүүхдийг шаардлагатай шатлалын тусламж үйлчилгээнд зөв илгээх, хяналт хийх чадавх сайжирна.
- Арклайт багажаар нүдний анхан шатны үзлэг хийх практик ур чадвар эзэмшинэ.

Засаг даргын 2026 оны
11 дугаар сарын 29-ны өдрийн
дугаар тушаалын II хавсралт

9043446 2020030036

Хүүхдийн нүдний үзлэгийн сургалт зохион байгуулах

үйл ажиллагааны зардал

№	Утга	Тоо	Нэгжийн үнэ	Өдөр	Нийт
1	Сургагч багшийн хөлс	2	300,000	2	1,200,000.00
2	Сургалтын зохицуулагч	2	150,000	2	600,000.00
3	Сургалтын өглөөний цай	41	15,000	2	1,230,000.00
4	Сургалтын хоолны зардал /өдрийн хоол/	41	35,000	2	2,870,000.00
5	Суралцагч нарт ус (савтай)	41	2500	2	205,000.00
6	1 удаагийн хэрэгсэл /Аяга. Халбага. Сальфитка/	41	3500	2	287,000.00
7	Шатахуун	35 литр	4650	2	325,500.00
8	Сумын томилолт	4	30,000	1	120,000.00
9	Бичиг хэргийн зардал (бал, дэвтэр, бичгийн цаас)	35	10,000	1	350,000.00
Нийт					7,187,500

Төсөв гаргасан: ХБӨТСХМ

А.Хонгорзул

Хянасан: ЭМЭЗТТЗХОБХМ

Д.Отгондэлгэр